

МОНГОЛ ДАХЬ СЭТГҮҮЛЧИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТ:
ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

Х.Энхтуяа*

* "Отгонтэнгэр" их сургууль, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, докторант

Түлхүүр үг: хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлч, нээлттэй ардчилсан нийгэм, дээд боловсрол, мэдлэгт суурилсан эдийн засаг, чанартай боловсрол, мэргэжлийн сургалт, боловсролын үнэлгээ, боловсролын стандарт, сургалтын дадлагын бааз, хэвлэл мэдээллийн байгууллага, эрх чөлөө.

Монгол оронд өрнийн иргэншил, орчин үеийн соёл нэвтрэхэд хэвлэл мэдээлэл, тэр тусмаа сонины гүйцэтгэсэн үүрэг аугаа их. 1934 онд бий болсон радио, 1967 онд орж ирсэн зурагт нь сонин хэвлэлтэй хавсран монголчуудыг өнөөгийн мэдээллийн глобальчлалд авч ирсэн.

90-ээд он хүртэл манайд чөлөөт мэдээллийн хэрэгслийн тухай ойлголт байгаагүй. Мэдээллийн хэрэгсэл бол МАХН-ын дайчин зэвсэг мөн гэж намын удаа дараагийн их хурлууд болон бусад бичиг баримтад нэг утгаар илэрхийлдэг байлаа. Сэтгүүлчийн ажлыг

намын үзэл суртлыг ард түмэнд хүргэгч, суртал нэвтрүүлгийн эрэлхэг дайчид, намын дайчин тэмцэгч, үзэг барьсан фронтын байлдагч гэж албан ёсоор томъёолдог байсан. Мэдээллийн хэрэгсэл нь ч, сэтгүүлчийн мэргэжил нь ч, сэтгүүлч мэргэжлийн диплом авсан хүн нь яг л энэ заагдсан үүргийг нэртөртэйгээр олон жил гүйцэтгэж, намынхаа итгэлийг ганц ч удаа хөсөрдүүлээгүй.

Харин өнөөгийн иргэншиж соёлжиж, техник технологийн шинэ эрэмбэд гарсан Монгол орны нээлттэй нийгмийн сэтгүүлч залуучууд ямар итгэл үнэмшил, ирээдүйн төсөөлөл, хайрлаж хүндэтгэдэг юм, ариун сайхан зүйлтэйгээр сурч боловсорч, ажиллаж хөдөлмөрлөж байгаа бол?

Нээлттэй ардчилсан нийгэм боловсролтой хүнд сайн сайхан амьдрах өргөн боломжийг нээж байдаг. Энэ бол маргашгүй үнэн. Чадварлаг боловсон хүчин бол хөгжлийн гол тулгуур юм.

Өнөөдөр боловсрол Монголын хамгийн гол баялаг. Хаа нэгтэйгээс олборлож байгаа алт, зэс байгалийн нөөц бидний нөөц болохоос бус, баялаг биш гэдгийг олонхоороо биш боловч багагүй хэсэг нь мэдэрч ойлгох болжээ.

1940 оны 12-р сарын 6-нд "Улаан-баатар хотод улсын университетийг байгуулах тухай"

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарч, зоотехник, сурган хүмүүжүүлэх, хүн эмнэлгийн гурван ангитайгаар Ардыг гэгээрүүлэх яамны харьяанд байгуулахаар шийдвэрлэсний дагуу 1942 оны 10-р сарын 1-нд манай улсын анхны дээд

боловсролын байгууллага болох Улсын Их Сургууль байгуулагдаж байсан бол 1990 оны ардчилсан шилжилт бидэнд шинэ боломжийг авч ирэн анхны хувийн дээд сургуулиуд шил шилээ даран үүд хаалгаа нээсэн.

Тэгвэл одоогоос 47 жилийн тэртээ анх хэвлэл мэдээллийн байгууллагуудыг сэтгүүлч боловсон хүчнээр хангах зорилгоор МУИС-д сэтгүүл зүйн ангийг нээж, сэтгүүлч мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж байсан тэр үе 1994 оноос өөрчлөгдөж, одоо улсын болоод хувийн хэвшлийн 21 их, дээд сургууль,

коллежид сэтгүүлчдийг бэлтгэн гаргах болсон байна.

Түүгээр ч зогсохгүй мэргэжлээрээ төгсөөд гарахад нь ажиллах ХМХ-үүд олноороо бий болж, сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд хуулнд заагдсан эрхийнхээ дагуу байгуулагджээ.

Энэ бол нөгөөх л нээлттэй ардчилсан нийгмийн ач буян. Нээлттэй ардчилсан нийгэмд зах зээлийн эдийн засгийн хөгжлийн замыг сонгосон нь монголчууд бидний цоо шинэ дэвшилтэт алхам байсан. Эдийн засгийн хөгжилд дээд боловсролын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд Монголын дээд боловсролын өөрийнх нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлага тавигдаж байна.

«
Нээлттэй ардчилсан нийгэмд зах зээлийн эдийн засгийн хөгжлийн замыг сонгосон нь монголчууд бидний цоо шинэ дэвшилтэт алхам байсан. Эдийн засгийн хөгжилд дээд боловсролын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд Монголын дээд боловсролын өөрийнх нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлага тавигдаж байна.

»

хариуцлагыг дээшлүүлэхэд Монголын дээд боловсролын өөрийнх нь өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлага тавигдаж байна. Чанаргүй боловсрол, ажилгүйчүүд. Энэ үг байнга холбоо үг болж сонсогдсоор удлаа. 160 гаруй их, дээд сургууль үйл ажиллагаагаа явуулж байгаа нь яах аргагүй иргэдийн сурч боловсрох хэрэгцээ шаардлага их байгааг харуулж байна. Энэхүү 160 гаруй их, дээд сургуулийн 10 гаруй хувьд нь сэтгүүлч мэргэжилтэн бэлтгэх сургалтын үйл ажиллагаа явагдаж байна. Монголын оюутны холбооноос

хийсэн сүүлчийн судалгаанаас үзвэл энэ жил нийт 120 мянган оюутан Улаанбаатар хотод суралцаж байна. Тэдгээрийн 1800 гаруй нь сэтгүүл зүйн ангийн оюутнууд. Үүнээс өмнө 2500 орчим сэтгүүлчид бэлтгэгдэн гарчээ. Харин эдгээр оюутнууд ямар мэдлэгийг олж авч, ямар чадвар сууж төгсөж байгаа нь харилцан адилгүй. Учир нь тэдний суралцаж төгсөн гарч байгаа их, дээд сургууль, коллежууд бүгд өөр өөрийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу сургалтын үйл ажиллагааг явуулж байгаа. Ерөнхий суурь мэдлэгийн, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн харьцаа сургууль бүрт харилцан адилгүй. Түүгээр ч зогсохгүй нэг ч удаа сонины эх бэлтгэж сонин гаргаж үзээгүй, радиогийн болон телевизийн нэвтрүүлгийн бичлэг хийж, түүнийгээ мэргэжлийн программ ашиглан компьютерт монтажилж үзээгүй оюутнууд ч төгсөн гарч байх жишээтэй. Судалгаа хийхэд РТДС, "Сэтгүүлч" коллежоос бусад сургуульд өөрийн радио, телевизийн сургалтын студи, фото студийн аль нэг нь огт байхгүй байлаа. Сургалтын студигүй, оюутан нь интернетээс мэдээлэл авах боломжгүй сургуулиуд ч байна. Сургалтын дадлагын бааз байхгүйгээр дан онол зааж сургаснаар бид чанартай сургалтыг явуулж чадахгүй.

МУИС, "Их Монгол" дээд сургуулийг эс тооцвол мэргэжилтэнг бэлтгэж

байгаа зарим сургуульд мэргэжлийн сургалт удирдан явуулах багшийн тоо маш цөөхөн байна. Бүр мэргэжлийн ганцхан багштай сургууль ч байх юм.

Монголын нийгэмд боловсролын үнэ цэнэ хэрэгцээ улам бүр өсч байна. Гэтэл энэ хэрэгцээнд чанартай үйлчилгээ дутаж байгааг дээд боловсролтой худалдагч авна гэсэн зараас бид харж байна. Сэтгүүлчийн диплом өвөртөл-'чихөөд ТҮЦ-ийн, дэлгүүрийн худалдагч хийх оюутанг бид сургаж мэргэжилтэй болгон төгсгөж байна уу аль эсвэл эх орондоо хэрэгцээтэй, хөрвөх чадвар сайтай мэргэжлийн ур чадвартай, мэдлэг оюунтай боловсон хүчнийг бэлтгэн гаргаад байна уу? Нэг талаас сургалтын үйл ажиллагааг явуулж байгаа байгууллагатай холбоотой ч нөгөө талаас дээд боловсрол эзэмшигчдийн дийлэнх нь ажилгүйчүүдийн эгнээнд орж, зарим нэг нь эзэмшсэн мэдлэгээ ашиглахдаа сул байгаатай энэ асуудал холбоотой.

Монгол хүн сайн боловсрол эзэмших шаардлагатай л байгаа бол бид энэ чиглэлд чармайн ажиллах ёстой.

Мэдлэгт суурилсан эдийн засгийн нөхцөлд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлж, хөгжлийн хөдөлгөх хүч болсон өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх гол уурхай нь их, дээд сургууль боллоо. Боловсролын хөгжлийн хандлага улам бүр олон талтай, олон хэмжүүртэй болж байгаа

боловч энэхүү олон талт байдлыг харилцан хүлээн зөвшөөрч ойлголцон ажиллах нийтлэг хандлага өргөжиж байна.

Энэ хүрээнд юуны өмнө дээд боловсролын стандартыг жигдлэх шаардлага хүчтэй тавигдаж байна.

Өнөөдөр боловсролын үнэлгээг сайжруулж чанартай боловсрол олгох явдал нь эдийн засгийн байдлаас хамааран өндөр өртөгтэй болж байгаа нь зайлшгүй нөхцөл. Гэтэл нийт ард иргэдийн амьжиргааны төвшин үүнийг дагаад өсч чадахгүй байгаагаас болж дээд боловсролыг дундаас доош орлоготой хэсгийнхэн эзэмших нь хүндрэлтэй болж байгаа гэхэд хилсдэхгүй.

Нэг оюутанд ноогдох хөрөнгө оруулалтаар манай үзүүлэлтийг бусад оронтой харьцуулах боломжгүй. Энэ байдлыг залруулахад сургалтын зээлийн бодлого дээр төрөөс онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Авьяас чадвартай оюутнууд төлбөрийн асуудлаас болж сурч чадахгүй байх нь улс оронд хохиролтой. Мэргэжлийн онцлог, шаардлагаас хамаарч сургалтын төлбөрийг анги бүрээр нь харилцан адилгүй тогтоох нь зайлшгүй болоод байна.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн байгууллагууд, тэдгээрт ажиллаж байгаа хашир туршлагатай сэтгүүлч, уран бүтээлчид ирээдүйн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж байгаа сургалт судалгааны байгууллагуудтай хамтран

ажиллаж, мэдлэг чадвар, туршлагаасаа хуваалцан оюутныг тухайн хэвлэл мэдээллийн газарт дадлага хийх бололцоог өргөжүүлж өөрийн үүд хаалгыг нээлттэй болгон улсын сургуулийнх, хувийн сургуулийнх гэж ялгалгүй, тэр ч бүү хэл сурч байгаа сургуулийнх нь нэр хүндээр нь дугаарлахгүйгээр хүлээн авч хамтран ажиллаж чадвал бид боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх бололцоотой юм.

Сүүлийн үед "блог" ашиглаж байгаа хүмүүс өөрсдийгөө үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвартай, юм бичдэг мундаг сэтгүүлчид, иргэний сэтгүүл зүйг хөгжүүлэгч сэтгүүлчид гэж үзэх болсон байна. Жолооч гэдэг мэргэжил өнөөдөр шинэ зууны шаардлагаар мэргэжил биш болоод хэрэгцээ болсон шиг сэтгүүлч ч бас мэргэжил биш, хүн болгоны хэрэгцээ шаардлага болжээ гэж ташааран явж буй хүмүүс байна. Энэ бол сэтгүүлч мэргэжлийг юм бичих дуртай, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлчихдэг хүн болгоны ажил хэмээн ташаа ойлгуулсан мэргэжлийн сэтгүүлчдийн бас нэгэн алдаа. Байгалиас заяасан төрөлх авьяас дээрээ 4-5 жил суралцаж, арван жил дагалдаж байж олж авдаг нарийн мэргэжил бол сэтгүүлч.

Ингээд эцэст нь хэлэхэд сэтгүүл зүйн сургалт судалгааны байгууллагууд харилцан хамтран ажиллаж, мэргэжлийн сургалтын стандартыг бий болгож, нэгэнт л сэтгүүл зүйн

Резюме

сургалтыг явуулж байгаа бол тухайн байгууллага чанартай үйлчилгээг үзүүлэх цаг ирснийг судалгаа харуулж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. З у л ь к а ф и л ь М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. Хоёр дахь хэвлэл. УБ.
2. З у л ь к а ф и л ь М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
3. 1998. Социология журналистики. М.
4. 2007. Баабар ингэж өгүүлэв. УБ.
5. <http://www.mecs.pmis.gov.mn/>

В этой статье автор затронул проблемы высшего образования современной Монголии, в том числе проблему подготовки профессионального журналиста. Как считает автор, нынешняя проблема подготовки журналиста объясняется новым учебным стандартом. Кроме того, здесь не последнюю роль играют такие факторы, влияющие на качество образования, как материально-техническая база для прохождения практики, коллектив опытных профессиональных преподавателей, а также совместная работа учебно-исследовательских организаций и средства массовой информации.